

## **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

### **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ**

**Салбарын зорилго:** Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын хамрах хүрээг өргөжүүлэн, гэр бүлд ээлтэй жендэрийн мэдрэмжтэй цогц бодлого хэрэгжүүлнэ.

#### **1.1.ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ**

**Зорилт 1. Эх хэл, соёл, ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэн хөгжүүлж, түүх, соёлын өвөө хамгаалан, үндэсний бахархлаа түгээн дэлгэрүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.1.1.1. Уламжлалт монгол ахуй, өв соёлоо сэргээж, монгол бичгийн бүх нийтийн хэрэглээг нэмэгдүүлэн, иргэдэд угийн бичиг хөтлүүлэх замаар монгол хүний удмын санг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

1.1.1.2. “Цахим соёл”, “Соёлын өв-Хөгжлийн дархлаа”, “Бүх нийтийн соёлын боловсрол” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, орон нутгийн соёл, урлагийн үйлчилгээнд иргэдийн оролцоо, цахим орчин дахь үндэсний соёлын нөлөөг нэмэгдүүлнэ.

1.1.1.3. Соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулж, Эрдэнэзуу, Шанхын хийдийг улсын хамгаалалтад авах ажлыг судалж шийдвэрлэнэ.

1.1.1.4. Орон нутгийн соёл судлалыг хөгжүүлэн, төв халхын үнэт зүйлсийг тодорхойлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.

1.1.1.5. Өвөрхангайн бахархал, үнэт зүйлийг цахим орчинд контент энтертаймент хэлбэрээр сурталчлах уран бүтээлийн нэгдлийг бий болгон хөгжүүлнэ.

1.1.1.6. Биет бус өвийг өвлөн уламжлуулах шавь сургалтыг хөгжүүлж, шилдэг өвлөн уламжлагчдыг дэмжин, төв халхын болон нутгийн онцлогтой өвийг хамгаалж, “Соёлын өв- хөгжлийн дархлаа” форумоос гаргасан “Арвайхээрийн тунхаглал”-ыг хэрэгжүүлнэ.

1.1.1.7. Эрдэнэ-Зуу, аймгийн Музейн үзмэрийн танилцуулгыг цахим /виртуаль, дижитал/ хэлбэрт шилжүүлж, нийтийн хүртээл болгоно.

**Зорилт 2. Соёл, урлагийн байгууллагын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг дэмжих замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг өргөжүүлэн, мэргэжлийн хүний нөөцөөр хангана.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.1.2.1. “Өвөрхангайн соёлын өдөр” арга хэмжээг жил бүр 2-3 суманд зохион байгуулж, Хархорин сумын Соёлын төвийг Соёл, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлж, соёл, урлагийн зарим байгууллагуудыг автомашинтай болгоно.

1.1.2.2. Соёл, урлагийн нэгдсэн арга хэмжээ, уралдаан, наадам зохион байгуулан, хүүхэд залуучууд, ардын авьяастнуудын авьяас билгийг нээн хөгжүүлж, түгээн дэлгэрүүлнэ.

1.1.2.3. Аймгийн Хөгжимт драмын театрын дотор их засварыг хийж, дуу, гэрэлтүүлэг, уран бүтээлчдийн хувцас, хэрэгслийг шинэчлэнэ.

1.1.2.4. Аймгийн Музейн барилгыг ашиглалтад оруулж, үзүүлэг дэглэлтийг хийн, үзмэрийг жил бүр 50.0-иас доошгүй сая төгрөгөөр баяжуулж, сумдын орон нутаг судлах танхимуудыг иргэд, байгууллагуудад тогтмол хугацаанд, хуваарийн дагуу үйлчилдэг болгоно.

1.1.2.5. Өлзийт, Баян-Өндөр, Нарийнтээл сумдын Соёлын төвийг засварлан өргөтгөж, Соёлын төвүүдийн тавилга, техник, хэрэгслийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, Хайрхандулаан, Есөнзүйл сумдын Соёлын төвийн дотор тохижилт, техник хэрэгслийн хүчин чадлыг сайжруулна.

1.1.2.6. “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээг хэрэгжүүлж, соёл, урлагийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

**Зорилт 3. Орон нутгийн соёл, урлагийн үйл ажиллагааны менежментийг сайжруулж, гадаад харилцааг хөгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.1.3.1. Иргэдэд зайны болон нүүдлийн соёл, урлагийн үйлчилгээг хүргэж, зарим сумдын Соёлын төвүүдийг соёлын өв хариуцсан ажилтантай болгоно.

1.1.3.2. Мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээл туурвих үйл ажиллагааг дэмжиж, урлагийн ажилтнуудыг дотоод, гадаадын сургалтад хамруулан, “Сонгодог урлаг-III” арга хэмжээг хэрэгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

1.1.3.3. Ном, соёлын үйлчилгээний оновчтой хэлбэрийг бий болгож, орон тоо, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх замаар номын санг цахим болгон хөгжүүлэн, аймгийн Номын сангийн фондод жил бүр 5-аас доошгүй сая төгрөгөөр баяжилт хийнэ.

1.1.3.4. Соёлын өв, урлаг, музейн үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон өргөжүүлж, “Торгоны зам-Хархорум”, “Өндөр Гэгээний соёлын өв уламжлагч” зэрэг соёл, урлаг, уран бүтээл, урлалын цогц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

## **1.2.ЭРҮҮЛ МЭНД**

**Зорилт 1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.2.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

1.2.1.2. Иргэн бүрийг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорт хавдрын 7 төрөл, артерийн даралт ихсэх, чихрийн шижингийн эрт илрүүлгийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулна.

1.2.1.3. Иргэдийн дунд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хүн амын зохистой хоололт, илүүдэл жин, таргалалттай тэмцэх, давсны хэрэглээг бууруулах арга хэмжээ
- Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, хорт зуршил, мансууралтай тэмцэх арга хэмжээ
- Арьс, харшлын өвчнийг бууруулах арга хэмжээ
- Осол, гэмтлээс сэргийлэх арга хэмжээ
- Хэрх, хэрх төст өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- “Хеликобактер”-гүй гэр бүл арга хэмжээ

1.2.1.4. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Орчны эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээ
- Сүрьеэ өвчинтэй тэмцэх арга хэмжээ
- БЗХӨ/ДОХ/Тэмбүү өвчнийг бууруулах арга хэмжээ
- Томуу, томуу төст өвчнийг бууруулах арга хэмжээ
- “Элэг бүтэн-Монгол” арга хэмжээ
- Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ

1.2.1.5. Нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ
- Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ
- Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээ

**Зорилт 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.2.2.1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд харвалт, шигдээсийн нэгж байгуулж, ангиографи, MRI, компьютер томографи аппарат, ходоодны уян дурангаар хангана.

1.2.2.2. Зооноз өвчин судлалын төв, сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн болон оношилгооны багажийн чадавхийг дээшлүүлэн, эмчилгээ, сувилгааны нэр төрлийг нэмэгдүүлнэ.

1.2.2.3. Эрүүл мэндийн салбарт эмнэлзүйн олон улсын стандарт UpToDate систем, бүртгэл, хяналтын цахим тогтолцоог нэвтрүүлэн, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2.2.4. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүчилтөрөгчийн үйлдвэрийг өргөжүүлж, Баянхонгор, Дундговь, Хархорины Нэгдсэн эмнэлгийг хангана.

1.2.2.5. Нотолгоонд тулгуурласан анагаах ухааныг хөгжүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбарын инноваци, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, практик хэрэглээг хөгжүүлнэ.

**Зорилт 3. Цахим эрүүл мэнд, эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлж, яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг хөгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.2.3.1. Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд мобайл технологийг нэвтрүүлнэ.

1.2.3.2. Оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.

1.2.3.3. Жирэмсний нэрийн хяналт, цэргийн үзлэг, эрүүл мэндийн хяналт, бэлгийн замын халдварт өвчний хяналтын программуудыг нэвтрүүлнэ.

1.2.3.4. Яаралтай тусламж үзүүлдэг нэгжийн тоог нэмэгдүүлнэ.

1.2.3.5. Гэмтлийн нарийн мэргэжлийн тусламжийг Хархорин, Уянга, Нарийнтээл, Бат-Өлзий, Богд, Хужирт, Хайрхандулаан, Есөнзүйл сумдад үзүүлдэг болгоно.

**Зорилт 4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлэн, чадавхийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.2.4.1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг резиденсийн сургалт явуулах эрхтэй байгууллага болгоно.

1.2.4.2. Эмнэлгийн эмчилгээний хоол, шим тэжээлийн мэргэжилтнийг бэлтгэнэ.

1.2.4.3. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.4.4. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын улирлын урамшуулал, ур чадварын нэмэгдлийг тэдгээрийн мэдлэг, ур чадвар, харилцаа, хандлага, ёс зүйн үнэлгээтэй уялдуулан олгодог тогтолцоонд шилжүүлнэ.

1.2.4.5. Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай орон тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

1.2.4.6. Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжил, боловсролыг дээшлүүлэх цахим зайн сургалтын системийг хөгжүүлж, тэдгээрийн 70-аас доошгүй хувийг зайн сургалтад хамруулна.

1.2.4.7. Эрүүл мэндийн салбарын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлж, жил бүр эмч, мэргэжилтнүүдийг гадаад улс оронд сургалтад хамруулна.

**Зорилт 5. Зарим төрөлжсөн төвүүд болон сумдын Эрүүл мэндийн төвүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.2.5.1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын өргөтгөл, эмийн агуулах, Зоонозын өвчин судлалын төвийн барилгыг шинээр барьж, уламжлалт, нөхөн сэргээх, амбулатори, шүдний гажиг засал, хөнгөвчлөх, сувिलाхуй зэрэг эмнэлгүүдийг хувийн хэвшилд тулгуурлан байгуулна.

1.2.5.2. Бат-Өлзий, Богд, Хужирт, Зүүнбаян-Улаан, Уянга, Нарийнтээл, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Өлзийт, Хайрхандулаан сумдын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Хархорин, Сант, Баян-Өндөр сумдын Эрүүл мэндийн төвийн их засвар, Уянга, Бат-Өлзий, Баянгол, Өлзийт, Гучин-Ус сумдын эмчийн байр шинээр барих, Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Бүрд сумдын эмчийн байрны их засварыг хийж, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хүүхдийн эмнэлгийг хатуу зөөлөн эдлэл, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

1.2.5.3. Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, түргэн тусламжийн автомашиныг үе шаттайгаар шинэчилж, хөдөөгийн багийн эмч нарыг унаажуулна.

1.2.5.4. Арвайхээр суманд Өрхийн эрүүл мэндийн төв нэмэгдүүлэх, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн харьяанд “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг амбулаторийн эмнэлэгтэйгээр байгуулах асуудлуудыг тус тус судлан шийдвэрлэж, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэгт чих, хамар хоолойн кабинет, бактериологийн лабораторийг шинээр байгуулна.

1.2.5.5. Баянтээг багийн эрүүл мэндийн төвийг уламжлалтын эмчилгээний үйлчилгээтэй болгоно.

1.2.5.6. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг олгох, үйлчлүүлэгч эмчээ сонгон эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулан, бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

### **1.3.БИЕИЙН ТАМИР**

**Зорилт 1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.3.1.1. Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн байгууллагуудад “Биеийн тамир, спортын хамтлаг” байгуулан эрчимжүүлж, үйл ажиллагааг нь тогтмолжуулан дэмжлэг үзүүлнэ.

1.3.1.2. Иргэдийн дунд “Миний нутаг сайхан” спортын наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

1.3.1.3. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох, заавал биелүүлэх норм, нормативын сорилыг насны ангиллаар жилд 2 удаа авч хэрэгжүүлнэ.

1.3.1.4. Сумдыг нийтийн биеийн тамирын арга зүйчтэй болгож, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

1.3.1.5. Биеийн тамирын зориулалтын зам, гадна талбай болон хүүхэд, залуучуудын спорт цогцолбор бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг нэмэгдүүлэн, нийтийн биеийн тамирын орчныг бүрдүүлнэ.

**Зорилт 2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.3.2.1. Өсвөрийн шигшээ багийг жүдо бөх, чөлөөт бөх, шатар, таеквондо, хүндийн өргөлт, хөнгөн атлетик, цана, волейбол, сагсан бөмбөг, теннисний спортын төрлүүдээр байгуулж, Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургуульд болон шаардлагатай спортын чиглэлүүдийн дасгалжуулагчийг орон тоогоор ажиллуулна.

1.3.2.2. Үндэсний болон багийн спортыг дэмжиж, олон улсын жишигт нийцсэн талбай бүхий зуны спортын цэнгэлдэх хүрээлэн, үндэсний спортын талбайг байгуулна.

1.3.2.3. Жилд 2 удаа нэрэмжит тэмцээнүүдийг зохион байгуулж, спортын холбоод болон тив дэлхий, олон улсын тэмцээнд оролцох тамирчдыг дэмжинэ.

1.3.2.4. Бат-Өлзий суманд олон улсын стандартад нийцсэн цанын бааз байгуулна.

1.3.2.5. “Усан спорт сургалтын төв”-ийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.3.2.6. Фитнесс клубуудыг мэргэжил арга зүйгээр ханган, магадлан итгэмжлэлд хамруулж, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

## **1.4.БОЛОВСРОЛ**

**Зорилт 1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.1.1. Арвайхээр хотод төвийн бүсийн “Хөгжим бүжгийн коллеж” байгуулна.

1.4.1.2. Арвайхээр, Бат-Өлзий, Өлзийт, Хужирт, Баянгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгыг шинээр барих, Арвайхээр сумын 4 дүгээр сургууль, Уянга сумын 1 дүгээр сургууль, Жаргалант багт сургуулийн өргөтгөл шинээр барина.

1.4.1.3. Арвайхээр, Бат-Өлзий, Есөнзүйл, Хархорин, Төгрөг, Уянга, Бүрд, Бат-Өлзий сумдад цэцэрлэгийн барилга шинээр барьж, Арвайхээр, Хархорин, Богд, Хужирт, Нарийнтээл, Өлзийт, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Баянгол сумдын цэцэрлэгийн өргөтгөл, их засварыг хийнэ.

1.4.1.4. Арвайхээр, Хархорин сумдад сургуулийн дотуур байр шинээр барина.

1.4.1.5. Арвайхээр /“Тэмүүлэл-Эрдэм”/, Сант, Хужирт, Бат-Өлзий, Хархорин /1 дүгээр болон Номын хүрдэн/ сумдын сургуулиудад спорт заал, Уянга сумын 1 дүгээр сургуульд урлаг заал тус тус шинээр барина.

1.4.1.6. Шаардлагатай сумдын сургуулиудад спорт тоглоом, хөл бөмбөгийн талбай шинээр барина.

1.4.1.7.Зарим сумдын сургууль, цэцэрлэгт хөргүүр бүхий мах, ногооны зориулалтын зорь, агуулах барих, сургууль, цэцэрлэг орчмын эзэмшлийн талбайн тохижилт, авто машины зогсоол бий болгоно.

1.4.1.8. Багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Багшийн хөгжлийн төв” байгуулж, түүнд тулгуурлан ахмад багш нарын идэвхи, оролцоотойгоор залуу багш, сурагчдад зориулсан дугуйлан, клуб ажиллуулна.

1.4.1.9. Сургууль, цэцэрлэгүүдийн цахилгаан хангамж, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар шинэчлэнэ.

**Зорилт 2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны сургалтын болон үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, ажиллана.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.2.1. Арвайхээр сумын 2 дугаар сургууль, Хайрхандулаан, Төгрөг, Баруунбаян-Улаан, Хархорин сумын 1, 2 дугаар, Уянга сумын 1 дүгээр сургуулиудын хичээлийн байранд их засвар хийх, Хужирт, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан, Уянга /2 дугаар сургууль/ сумдын сургуулийн сантехникийн засвар, Баян-Өндөр сумын сургуулийн дээврийн засварыг тус тус хийнэ.

1.4.2.2. Уянга сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Хужирт, Бүрд сумдын спорт зааланд их засвар хийнэ.

1.4.2.3. Арвайхээр, Хархорин, Богд, Нарийнтээл, Өлзийт, Төгрөг, Бүрд, Хужирт, Есөнзүйл сумдын цэцэрлэгт их засвар, Хужирт сумын 2 дугаар цэцэрлэгт сантехникийн засвар хийнэ.

1.4.2.4. Төгрөг, Сант, Бат-Өлзий, Өлзийт, Есөнзүйл сумдын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад их засвар хийнэ.

1.4.2.5. Сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийж, стандартад нийцүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

**Зорилт 3. Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.3.1. Ерөнхий боловсролын сургуулиудыг шаардлагатай кабинет, лаборатори, цахим тоног төхөөрөмжөөр хангана.

1.4.3.2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангах, хатуу зөөлөн эдлэлийг шинэчлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.4.3.3. Сургууль, цэцэрлэг, дотуур байруудыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгоно.

1.4.3.4. Боловсролын байгууллагуудын хичээлийн болон дотуур байруудад орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камерын тоог нэмэгдүүлнэ.

1.4.3.5. Цэцэрлэгүүдийн гадна тоглоомын талбайн тохижилтыг стандартын шаардлагад нийцүүлэх, тоглоом сургалтын хэрэглэгдэхүүний хангалтыг сайжруулна.

1.4.3.6.1-2 настай хүүхдийг яслид, 2-3 настай хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд, 3-5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд /5 настныг заавал/ хамруулж, хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.

1.4.3.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлэх, шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж, багшлах боловсон хүчнийг давтан сургах, мэргэшүүлэх, жирийн ангид шилжин суралцах чадварыг дээшлүүлэн, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.

1.4.3.8. **Арвайхээр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийг биеийн тамирын төрөлжсөн сургууль болгоно.**

1.4.3.9. Хүүхэд бүрийг сургуульд тэгш хамруулах боловсролын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж байгаа "Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь", "Орон



нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох" төслүүдийг хамтран хэрэгжүүлнэ.

**Зорилт 4. Сургууль бүрт үйлчилгээний стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрдүүлж, бүх сурагчдыг үдийн хоолны хөтөлбөрт хамруулна.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.4.1.Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.4.4.2.Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын гал тогоог стандартын шаардлагад нийцүүлэх, засварлах, зориулалтын хөргүүрийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хоол зүйч, хоол үйлдвэрлэлийн технологич орон тоогоор ажилуулна.

1.4.4.3.Сургууль, цэцэрлэгүүдэд туслах болон хүлэмжийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.

**Зорилт 5. Боловсролын үйлчилгээг чанартай зохион байгуулж, сургалт, хүмүүжлийн ажлын чанарыг дээшлүүлж, дотоод, гадаадын их дээд сургуульд хүлээн зөвшөөрөгдсөн суралцагчийг бэлтгэнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.5.1.Улсын төрөлжсөн олимпиадыг орон нутагтаа зохион байгуулж, багш, сурагчдын чадавхийг дээшлүүлнэ.

1.4.5.2.Таваас доошгүй хичээл судлагдахуунаар анги нийтийн аймгийн олимпиад уралдаан зохион байгуулж, анги хамт олны амжилтыг үнэлж, дүгнэнэ.

1.4.5.3.Цэцэрлэг, сургууль бүр үйл ажиллагаандаа өөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог хөгжүүлж, жилд 10-аас доошгүй цэцэрлэг, сургууль хөндлөнгийн үнэлгээнд хамрагдана.

1.4.5.4. Хүүхэд нэг бүрийг ёс зүйтэй бие хүн болгон төлөвшүүлэн, хүмүүжүүлэхэд багш, эцэг, эх, нийгмийн ажилтны хамтын оролцоог хангаж, зарим сургуулиудад сэтгэл зүйчийг орон тоогоор ажиллуулна.

1.4.5.5.“Шатар” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.4.5.6.Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах санаачилгыг дэмжин ажиллана.

1.4.5.7.Багш, удирдах ажилтны ажлын арга барил, үйл ажиллагааны үр дүн, ур чадварын түвшин тогтоох, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор багш, удирдах ажилтныг аттестатчилна.

1.4.5.8. Ерөнхий боловсролын сургалтын чанарын үндэсний үнэлгээнд жил бүр амжилтаа ахиулан, сургуулиудыг олон улсын PISA үнэлгээнд хамруулж, улсын дунджаас дээгүүр үнэлэгдэх зорилт тавин ажиллана.

**Зорилт 6. Сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос бичигтэн болох зэрэг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.6.1. Жил бүр аймаг байгуулагдсан тэмдэглэлт өдрийг угтан аян зохион байгуулж, “Миний Өвөрхангай” сургалтын хөтөлбөр боловсруулан гарын авлага бэлтгэж, түүгээр ерөнхий боловсролын бүх сургуулиудад хичээл зохион байгуулж, хэвшинэ.

1.4.6.2. Суралцагчдын сонирхол, хэрэгцээнд тулгуурлан гүнзгийрүүлсэн, төрөлжсөн болон сургалтын хөтөлбөрийг зарим сургуулиудад хэрэгжүүлнэ.

1.4.6.3. Сургуулийн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын санал санаачлагыг дэмжиж хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, бие даан бүтээлчээр суралцахууд суралцах боломжийг нээн, сургуулийн харьяа уламжлалт өв соёл, хэл, сэтгэн бодох, техник технологи, оюуны спортын төрлийн клуб, төв, дугуйлан, секцэд хичээллэх сурагчдын тоог нэмэгдүүлнэ.

1.4.6.4. Хичээлээс гадуурх сургалтын төвүүдэд сургалтын хөтөлбөртэй байх шаардлага тавьж, зөвшөөрөл олгох ажлыг судлан хэрэгжүүлнэ.

1.4.6.5. Хүүхдийн зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэднийг хөдөлмөрт сургах, хамтарч ажиллах, чадвар эзэмшүүлэх зорилгоор сумдын дунд өрсөлдөөн бий болгох замаар “Хөдөлмөр зуслан”-г сургуулиудыг түшиглэн хөгжүүлнэ.

**Зорилт 7. Нээлттэй боловсролын тогтолцоог бий болгон цахим болон зайн сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн, бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, бүх насны суралцагч, иргэдэд зориулсан цахим сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулан түгээнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.7.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг интернэт сүлжээнд 100 хувь холбож, хурдыг нэмэгдүүлнэ.

1.4.7.2. Суралцагчдын тест, сорил, шалгалтын материалыг богино хугацаанд үнэлж, үр дүн, тайлан мэдээллийг олон төрлөөр боловсруулах хүчин чадалтай программ, техник хэрэгслээр сургалт арга зүйн байгууллага болон Ерөнхий боловсролын сургуулиудыг хангана.

**Зорилт 8. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгож, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.8.1. Салбарын албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрүүл мэнд хөдөлмөрийн үнэлэмж, орон байрны нөхцлийг сайжруулах асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

1.4.8.2. Багш, удирдах ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх "Багшийн цахим кампус" зайн сургалтын системийг хөгжүүлж, багш нарын 70-аас доошгүй хувийг зайн сургалтаар мэргэжил, боловсролыг нь дээшлүүлнэ.

1.4.8.3. Боловсролын салбарын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлж, жил бүр багш, удирдах ажилтан, мэргэжилтнийг гадаад улс оронд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.

1.4.8.4. Багш нарын заах арга зүйн хөгжлийг дэмжих тэргүүн туршлага, ур чадвараа түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Багш, сурагч солилцоо"-ны арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.8.5. Багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, багш нарын ажлын үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор "Чадварлаг багш" арга хэмжээг зохион байгуулж, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээр шинэ бүтээл, оновчтой санал /инноваци/ нэвтрүүлсэн багш, удирдах албан хаагч нарт урамшуулал олгоно.

**Зорилт 9. Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.4.9.1. Цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.

1.4.9.2. Насан туршийн боловсрол олгох сургалтыг бизнес, амьдрах ухаан, хүний хөгжил, ёс суртахуун, гоо зүй, гэр бүл, байгаль орчны, иргэний боловсрол (эрх зүй, эрүүл мэнд, гамшгаас хамгаалах) олгох чиглэлээр сургалтын олон талт хэлбэрээр зохион байгуулна.

1.4.9.3. Насанд хүрэгчдийн тасралтгүй сургалт болон ерөнхий боловсрол нөхөн олгох сургалтыг зохион байгуулна.

1.4.9.4. Монгол бичигт суралцах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлнэ.

## **1.5. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ**

**Зорилт 1. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхижсан гэр бүлийг төлөвшүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.5.1.1. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, нотолгоонд тулгуурлан гэр бүлийн боловсрол олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.5.1.2. Залуу гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг

нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагыг дэмжин хамтран ажиллана.

1.5.1.3. Айл өрхүүдийг гадна дэд бүтэцэд холбох, гадна орчны тохижилтыг сайжруулах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн, цахим орчинд гэр бүлийн зүй зохистой харилцааны талаархи мэдээллийг түгээх замаар гэр бүлд ээлтэй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.

1.5.1.4. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах чиглэлээр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана.

1.5.1.5. Хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх ажлыг салбар дундын зохицуулалтаар хангаж, гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, гэр бүл салалтын эсрэг хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, стрессийн сэтгэл зүйч ажиллуулна.

1.5.1.6. Хүүхдийн болон гэр бүлийн зусланг байгуулж, гэр бүл, хүүхдэд ээлтэй үйлчилгээг бий болгоно.

**Зорилт 2. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулан, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.5.2.1. Хүүхдийн ордны үйл ажиллагааны менежментийг сайжруулж, түүнд даам, шатар, математик, англи хэл, дуу хөгжим, бүжиг зэрэг хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх чиглэлээр багшийн орон тоог шийдвэрлэн, зарим төрлийн дугуйлан, сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

1.5.2.2. Мэргэжлийн судалгааны байгууллагуудтай хамтарч, хүүхдийн эрсдэлийн мэдээллийн сан бий болгож, хүүхэд хамгааллын хамтарсан багийг чадавхижуулах, үйл ажиллагааг санхүүжүүлэх тогтолцоог бий болгоно.

1.5.2.3. Төр, хувийн хэвшлийн байгууллагуудад “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлж, “Гэр бүлийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хүүхэд хамгааллын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.

**Зорилт 3. Залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн орчин нөхцөлийг бүрдүүлж, тэдний оролцоог хангах олон талт арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн идэвхтэй гишүүн болгоход дэмжлэг үзүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.5.3.1. Залуучуудад бүх чиглэлээр хөгжих орчинг бий болгох зорилгоор “Залуучуудын хөгжлийн төв”-ийг шинээр байгуулан, стандартын дагуу тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.5.3.2. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хөдөөгийн залуучуудыг хөгжүүлэх, эрүүл амьдралын зөв хэв маягт суралцах явуулын үйлчилгээг нэвтрүүлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.

1.5.3.3.Залуучуудын хөгжлийн бүлэг, клубын үйл ажиллагааг болон сайн дурын ажил, санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.

**Зорилт 4. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тасралтгүй хөгжүүлэх, тэдний эрэлт хэрэгцээнд суурилсан хөгжил оролцоог хангасан салбар дундын зохицуулалт хийж, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.5.4.1.Бүх сумдыг ахмадын хөгжлийн төвтэй болгож, үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.5.4.2. Ахмад настны насан туршдаа суралцах боломжоор ханган, насан туршийн боловсрол төв, нэгжүүдтэй хамтарсан сургалт, уулзалт арга хэмжээг тогтмол зохион байгуулж, аж ахуйн нэгж байгууллагуудад ахмадын зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.5.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд суурилсан сэтгэлзүйн болон сэргээн засах сургалт арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хөгжих оролцох боломжийг сайжруулах багц арга хэмжээг авч хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийг байгуулна.

## **1.6.ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦ**

**Зорилт 1. Шинжлэх ухаан, технологи, инновацид тулгуурласан судлаачдын зөвлөлийг байгуулж, салбар бүрт судалгаа, шинжилгээнд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.6.1.1. Аймгийн хөгжилтэй холбоотой эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг жил бүр зохион байгуулж, илтгэлүүдийн эмхэтгэлийг гаргаж, нутгийн гаралтай эрдэмтэн судлаачдын санал, дүгнэлтийг орон нутгийн бодлогод тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

1.6.1.2. Орон нутгийн болон бүсийн хэмжээний эрэлт, хэрэгцээнд нийцэхүйц их, дээд сургууль байгуулах боломжийг эрэлхийлж, олон талт суурь судалгаа хийнэ.

1.6.1.3. Төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, их дээд сургууль, судалгааны институцитэй хамтарсан судалгааны шинжилгээ, инновацийн төв байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

**Зорилт 2. Техник, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын үйл ажиллагааг тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлогод нийцүүлэн хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан төгсөгчдийг ажлын байраар хангана.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ.

1.6.2.1. Техникийн болон мэргэжлийн боловсролын элсэлт-сургалт-төгсөлтийн бүх шатанд нийгмийн түншлэгч, ажил олгогч, мэргэжлийн холбоодын үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэн, боловсролын чанарыг дээшлүүлж, хамтын ажиллагааг тасралтгүй өргөжүүлж ажиллана.

1.6.2.2. Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд хамруулж, тэднийг тогтвортой ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

1.6.2.3. Техник, мэргэжлийн боловсрол сургалтын үйл ажиллагаанд цахим сургалтын орчин бүрдүүлж, үнэлгээ, бүртгэл мэдээллийн систем болон мэргэжлийн багш нарыг хөгжүүлж, орчин үеийн жишиг төв байгуулна.

1.6.2.4. Техник, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш, ажилтнуудыг дотоод, гадаадын дэвшилтэт технологи бүхий байгууллагуудад дадлагажуулах, ур чадварыг нэмэгдүүлэх, бүтээлч санаа, инноваци, судалгаа шинжилгээний ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

## **1.7. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**

**Зорилт 1. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангаж, халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.7.1.1. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн бодлогод тулгуурлан, салбар бүрт шинээр бий болох ажлын байрыг төлөвлөн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулан, ажилд зуучлах замаар 8.0 мянгаас доошгүй ажлын байр бий болгоно.

1.7.1.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн чиг хандлагад нийцүүлж, үйлчилгээний болон бусад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд 10.0 мянган иргэнийг хамруулна.

1.7.1.3. Харьцангуй бага хэрэглээтэй, дунджаас доогуур түвшний орлогтой өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн иргэнийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.7.1.4. Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийг шинэчлэн сайжруулж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.7.1.5. Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн зээл, төсөл, хөтөлбөрт хамруулан хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

**Зорилт 2. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төр, хувийн хэвшлийн байгууллагууд, ажилтан, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.7.2.1. Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг чадавхижуулна.

1.7.2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөлөөс үзлэг шалгалт, зөвлөн туслах, сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

1.7.2.3. Хувийн хэвшлийн байгууллагуудын хөдөлмөрийн харилцаа, цалин, хөлсний олголтод хяналт тавьж ажиллана.

**Зорилт 3. Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.7.3.1. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн өрхүүдийг оновчтой тодорхойлно.

1.7.3.2. Зорилтот бүлгийн өрхүүдийн дунд бүлэг, хоршоо байгуулан, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр дэмжин ажиллана.

1.7.3.3. “Нэг өрх - Нэг ажлын байр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар нийгмийн халамжийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай өрхийн тоог бууруулна.

1.7.3.4. Нийгмийн халамжид хамрагдахад шаардагддаг материалыг цахимаар хүлээн авч, иргэдэд шуурхай үйлчилнэ.

1.7.3.5. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг сумдад хийж, шаардагдах зардлыг төсөвт тусган хэрэгжүүлнэ.

1.7.3.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог сайжруулж, тэдний эрхийг хангах төрийн бус байгууллагуудыг чадавхижуулна.

**Зорилт 4. Нийгмийн даатгалын мэдээллийг бүрэн цахимжуулан, иргэд даатгуулагчдад үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.7.4.1. Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сан бүрдүүлж, архивын цахим лавлагааны үйлчилгээг жигдрүүлж, иргэд даатгуулагчдад шуурхай үйлчилгээ үзүүлнэ.

1.7.4.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.7.4.3. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хурлын үйл ажиллагааг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хурлыг цахимаар хийнэ.

1.7.4.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын дүрэм, журмын биелэлтийг хангаж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр сургалт зохион байгуулна.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ**

**Салбарын зорилго:** Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлэн, олон тулгуурт эдийн засаг бүхий өрсөлдөх чадвартай аймаг болно.

### **2.1.Эдийн засаг**

**Зорилт 1. Аймгийн эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, худалдаа, үйлчилгээ, тээвэр логистикийн салбарыг хөгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.1.1.1. Арвайхээр хотод түүхий эд, барилгын материалын бөөний төв байгуулж, сумдад худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуйн чиглэлээр аж ахуйн нэгж байгуулах санаачилгыг дэмжинэ.

2.1.1.2. А0301, А0302 улсын чанартай авто замын дагуух Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хайрхандулаан сумдыг хатуу хучилттай авто замаар холбох, “Арвайхээр-Хужирт-Бат-Өлзий”, “Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан”, “Арвайхээр-Баянгол-Сайхан Овоо-Цогт овоо”, “Арвайхээр-Гурван тэс-Шивээхүрэн”, “Чойр-Мандалговь-Арвайхээр”, А0302 улсын чанартай авто замаас Баянтээг баг хүртэлх 22 километр авто замуудыг шинээр барих зураг төсвийг хийлгэж, барьж эхлүүлнэ.

2.1.1.3. Хархорин сумыг аялал жуулчлал, түүх соёлын төв болгон хөгжүүлж, нисэх буудлыг олон улсын “4С” зэрэглэл бүхий агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор болгоно.

2.1.1.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үйлдвэр, худалдаа, үйлчилгээний бизнесийн таатай орчныг бүрдүүлж, түүхий эдийн нөөцөд тулгуурлан бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластер хэлбэрээр хөгжүүлнэ.

2.1.1.5. Бүх төрлийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж хөгжүүлнэ.

### **2.2.Санхүү, төсөв**

**Зорилт 1. Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.2.1.1. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавина.

2.2.1.2. Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллана.

2.2.1.3. Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулна.



2.2.1.4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө эдийн засаг, нийгмийн үр ашгийг тооцон, ач холбогдлоор нь эрэмбэлж хэрэгжүүлнэ.

2.2.1.5. Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа дотоодын давуу эрхийн зөрүү тооцох замаар орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

2.2.1.6. Цахим тендер шалгаруулалтыг нэмэгдүүлж, цахим системийн хөгжил, шинэчлэлийг ашиглана.

2.2.1.7. Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлнэ.

**Зорилт 2. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.2.2.1. Татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, татварын багц хуулийн шинэчлэлийг таниулж, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг өөрчлөн, заавар, зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулна.

2.2.2.2. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн салбар компаниудыг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгон, татварын бааз суурийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.2.2.3. Сум тус бүрийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцон гаргаж, шинээр байгуулагдсан үйлдвэр, үйлчилгээ, бүтээгдэхүүний мэдээллийг тухай бүрт нь үнэн бодитоор гаргаж, албан ёсны статистик мэдээлэлд хамруулна.

**Зорилт 3. Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, цахим санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.2.3.1. Иргэдэд хөрөнгийн зах зээл, үнэт цаасны арилжаанд оролцох чадавхийг нэмэгдүүлэх сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

2.2.3.2. Иргэдийг мөнгөн тэмдэгтийн зохистой хэрэглээнд уриалж, банк, даатгалын байгууллагын аюулгүй цахим бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.

2.2.3.3. Иргэн бүрийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлж, “Хуримтлалтай иргэн” аяныг мэргэжлийн болон бичил санхүүгийн байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ.

**Зорилт 4: Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн засаглалын менежментийг сайжруулж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.2.4.1. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн дүрэм журмыг шинэчилж, төлөөлөн удирдах зөвлөл, удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг хуулийн дагуу томилон, сургалтад хамруулан чадавхижуулна.

2.2.4.2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулна.

2.2.4.3. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд ногдол ашгийн төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

2.2.4.4. Бие даан ажиллах боломжтой зарим орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тодорхой хувийг менежментийн гэрээгээр хувьчлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж эхэлнэ.

2.2.4.5. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.

### **2.3.Уул уурхай, хүнд үйлдвэр**

**Зорилт 1. Орон нутгийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах уул уурхайн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.3.1.1. Баянтээгийн уурхайн ашиглалтын талбай, түүний нөөцийг нэмэгдүүлж, 20 МВт-ийн цахилгаан станц барих төсөлд орон нутгийн зүгээс шаардлагатай бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.

2.3.1.2. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөж, өөрийн болон зэргэлдээх аймгуудын хэрэгцээг ханган, төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулна.

2.3.1.3. Сайжруулсан шахмал түлш борлуулах түгээлтийн сүлжээ бий болгон, шахмал түлш хэрэглэх, угаарын хийнээс урьдчилан сэргийлэх талаар иргэдэд мэдээлэл, зөвлөмж түгээх, сургалт зохион байгуулж, шаардлагаатай бүтэц, орон тоог шийвэрлэнэ.

**Зорилт 2. Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр уул уурхайн орд газруудад хийгдэх геологи, хайгуул судалгааны ажлыг дэмжин, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.3.2.1. Нөөц өсөх боломжтой илэрц ордуудын судалгааг нарийвчлан гаргаж, улсын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр уул уурхайн орд газруудад хийгдэх геологи, хайгуул судалгааны ажлыг дэмжин, ажлын тайлан, үр дүнг хүлээн авч, мэдээллийн сан үүсгэн, баяжилт хийнэ.

2.3.2.2. Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр хийгдсэн тухайн жилийн геологи, хайгуул, судалгааны ажлыг хуулийн хүрээнд дэмжинэ.

2.3.2.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг хэрэгжүүлэн, бичил уурхайчдад мэргэжил арга зүй, хууль эрх зүйн туслалцаа үзүүлэн, хуулийн хүрээнд дэмжиж тэдний үйл ажиллагаанд төрийн болон иргэдийн оролцоотой хяналт тавьж ажиллана.

2.3.2.4. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлагыг сайжруулж, ашиглалтыг хуулийн хүрээнд явуулна.

**Зорилт 3. Уул уурхайн олборлох салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг хөгжүүлж, нийгмийн хариуцлагын гэрээг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.3.3.1. Уул уурхайн олборлох, байгалийн нөөц ашиглах салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын гурван талт бүтцийг хөгжүүлж, нийгмийн хариуцлагын гэрээг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.

2.3.3.2. Байгалийн баялгийг ашиглах талаар төр, хувийн хэвшил, иргэдийн мэдээллийн зөрүүг арилгаж, уул уурхайн эдийн засаг, нийгмийн ач холбогдлын талаар иргэдийг мэдээллээр хангаж ажиллана.

#### **2.4. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа үйлчилгээ**

**Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлэх бодлого баримталж, бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлж хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангана.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.4.1.1. “Баянгол омог”-ийн хонин сүргийг “Баянгол үүлдэр” болгох, Гучин-Ус сумын Монголын хоолойн тэмээ, Нарийнтээл сумын Тээлийн улаан ямаа, Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар цармын сарлаг үхрийн биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгаа хийж, шаардлага хангасан үүлдэр, омог, хэвшлийн малыг баталгаажуулан, мал үржлийн ажлыг үр дүнтэй зохион байгуулна.

2.4.1.2. Цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэн, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна.

2.4.1.3. Мал сүргийг бэлчээрийн даацад тулгуурлан сүргийн тоо толгойг зохистой хэмжээнд барьж, чанартай малтай малчдыг урамшуулан, зарим иргэдийг малжуулах төсөлд хамруулан залуу малчдыг бэлтгэж, тэднийг туршлага судлуулах дотоод, гадаадын арга хэмжээнд хамруулна.

2.4.1.4. Газар тариалан бүхий нутаг, төв суурин газруудыг түшиглэн өндөр ашиг шимтэй мах, сүүний, хосолмол үхрийн эрчимжсэн аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.4.1.5. Аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг орон нутгаас бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулан, түүнийг газар талбай, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үр ашигтай ажиллуулна.

2.4.1.6. “Малын тоо толгойн албан татварын тухай” хуулийн дагуу татварын хувь хэмжээг тогтоохдоо бэлчээрийн даац, малын тоо толгойгоос чанарт шилжүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

2.4.1.7. Бэлчээр ашиглалтыг сайжруулах аймгийн журам гарган бэлчээрийг усжуулах, сэлгэж өнжөөх, хортон мэрэгчээс хамгаалах зэргээр менежментийг нь сайжруулан отрын бүс нутгийн бэлчээрийг нэмэгдүүлнэ.

2.4.1.8. Мал үржүүлэг, технологийн хувийн нэгжийг сумдад байгуулахад хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулан, мал аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийг давтан сургалтад хамруулж, мэргэшүүлнэ.

2.4.1.9. Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.

2.4.1.10. Мал аж ахуйн салбарт мал засах буюу хөнгөлөх ажилд “Төөнөж-таслах” шинэ техник, арга технологийг нэвтрүүлэн эр төлийг (хурга) 5-6 сарын богино хугацаанд махны чиглэлээр эрчимтэй өсгөн бойжуулж, махны гарцыг 30-40 хувиар нэмэгдүүлэн, эдийн засгийн эргэлтэд оруулна.

2.4.1.11. Мах, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн бааз, хөргүүртэй зоорь, агуулахыг бүсчлэн барьж байгуулна.

**Зорилт 2. Малын халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэж тайван байдлыг хадгалан, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, экспортлох боломжийг бүрдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.4.2.1. Мал сүргийг угаалга, тарилга, туулгалтад бүрэн хамруулж, малын эмч болон мал эмнэлгийн нэгжийн тоог нэмэгдүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.4.2.2. Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай төхөөрөмжөөр бүх сумын малын эмч, мэргэжилтнүүдийг ханган мал эмнэлгийн үйлчилгээг цахимжуулна.

2.4.2.3. Мал сүрэгт түүврийн аргаар шинжилгээ хийж, түүний дүнг үндэслэн тухайн бүс нутгийг мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болохыг баталгаажуулж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдүүлнэ.

2.4.2.4. Малчдыг малын эм, био бэлдмэлийг зохистой хэрэглэх арга зүйн талаарх сургалт, мэдээллээр хангаж, эмийн үнэд хяналт тавина.

2.4.2.5. Мал эмнэлгийн газрын лабораторийг мах, сүүнд шинжилгээ хийдэг /эм, тарианы үлдэгдэл илрүүлэх/ тоног төхөөрөмжөөр хангана.

**Зорилт 3. Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, шинэ нэр төрлийн таримлыг тариалах замаар импортын хэрэглээг бууруулна.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.4.3.1. Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, тариаланчдыг үр, бордоо, техникийн дэмжлэгт хамруулан, дотоодын хэрэгцээний үр тарианы 60, төмс, хүнсний ногооны 70 хувийг тус тус хангана.

2.4.3.2. Сумдын атаршсан талбайг эргэлтэд оруулж, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэн, отор нүүдлийг багасгаж, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.

2.4.3.3. Хужирт, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий сумдад хөдөө аж ахуйн агро парк, Арвайхээр суманд хүнсний ногооны төрөлжсөн, механикжсан зоорь, худалдааны төв барих, бусад сумдад өвөл, зуны хүлэмжийн аж ахуй эрхлэхийг тус тус дэмжинэ.

2.4.3.4. Арвайхээр сумын Дайрга, Тарагт сумын Хүрэмт, Өлзийт сумын Хүйс, Баруунбаян-Улаан сумын Дөхөм, Бүрд сумын Их боригдойн тариалангийн талбайн услалтын системийн засвар шинэчлэлийн ажлыг хийж, Арвайхээр сумын Дайргын голын тариалангийн талбайг цахилгаанаар хангана.

**Зорилт 4. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.4.4.1. Хүн амын хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн зэрэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах замаар шимт, тэжээллэг чанарыг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулна.

2.4.4.2. Арвайхээр, Бат-Өлзий, Уянга, Богд, Хархорин, Хужирт, Баян-Өндөр болон бусад сумдад малын гаралтай түүхий эдэд түшиглэсэн ноос, ноолуур, арьс, шир, борц, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо боловсруулах үйлдвэр, цех байгуулах, бүх сумдад стандартын шаардлага хангасан мал нядалгааны цэг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

2.4.4.3. Хархорин суманд гурил, тэжээлийн үйлдвэр байгуулах, Хужирт сум дахь малын тэжээлийн үйлдвэрийг түүхий эдээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

2.4.4.4. Аймгийн онцлог түүхэн өв уламжлал бүхий бэлэг дурсгал, гар урлал, үндэсний дээл хувцас, гоёл чимэглэл, уран хатгамал зэрэг брэндэд чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.4.4.5. Арвайхээр сумын “Өвөрхангайд үйлдвэрлэв” худалдааны төв, Хархорин сумын “Борлуулалтын цэг”-ээр дамжуулан орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг худалдаалах боломжийг бүрдүүлэн, хэвлэл мэдээлэл, цахим орчинд сурталчлан таниулж, онлайн худалдааг хөгжүүлнэ.

2.4.4.6. Орон нутгийн махны үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг Сансар, Номин худалдааны төвийн сүлжээ дэлгүүрүүдээр борлуулах тогтолцоог бий болгоно.

2.4.4.7. Мах боловсруулах үйлдвэр, мал төхөөрөх цехүүдийг түшиглэсэн малын гаралтай дайвар бүтээгдэхүүн /өлөн гэдэс, яс, эвэр, туурай, өөх, тос, сэвс/ боловсруулах кластер хэлбэрийн үйлдвэрүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

## **2.5.Барилга, хот байгуулалт, газрын харилцаа**

**Зорилт 1. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн оролцоотойгоор иргэдийг тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.5.1.1. Дэд бүтцийн асуудлыг орон нутгаас шийдвэрлэх замаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, нийтийн болон түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.5.1.2. Зарим сумдын төвийн цэвэр усны болон ариутгах татуургын нэгдсэн байгууламж, дулааны төвлөрсөн системийг бий болгон, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, айл өрхүүдийг холбогдох нөхцөлийг бүрдүүлж, “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.5.1.3. Арвайхээр, Хужирт, Уянга, Нарийнтээл сумдад үерээс хамгаалах далан сувгийн байгууламжийн зураг төсвийг боловсруулж, угсралтын ажлыг гүйцэтгүүлнэ.

2.5.1.4. Төрийн байгууллагуудад дулааны тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулна.

2.5.1.5. Орон сууцны дундын өмчлөлийн шугам сүлжээ, цахилгаан шат, нийтийн эзэмшлийн зам талбай зэрэг эд хөрөнгийн өмчлөлийг тодорхой болгох, засвар, ашиглалтыг мэргэжлийн байгууллагад хариуцуулах, түүний үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтыг сайжруулна.

2.5.1.6. Барилга угсралтын ажилд дэвшилтэд технологи бүхий материал ашиглах, нийтийн орон сууцнуудын барилгын давхар бүрт дулааны узель болон хэрэглээний халуун усны шугамтай байх, гадна фасадыг металл хавтангаар хийх, гадна талбайн тохижилт, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийг бүрэн хийх зэрэг шаардлагыг техникийн нөхцөл, зургийн даалгаварт тусгаж, дулаан үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүч, шинэ технологийг нэвтрүүлнэ.

2.5.1.7. Аймгийн төвийн насжилт ихтэй хуучны орон сууцнуудыг дахин төлөвлөж, барилга байгууламжуудыг паспортжуулах ажлыг эхлүүлж, нийтийн орон сууцны хуучин барилгуудын дээвэр, фасадыг үе шаттайгаар засварлаж, орц, дундын эзэмшлийн талбай, гадна тохижилтыг оршин суугчдаар нь засварлуулж, хэрэглээний халуун усаар бүрэн хангана.

2.5.1.8. Сумдын гэрэлтүүлэг, ногоон байгууламж зэрэг нийтийн эзэмшлийн зам, талбайн засвар, үйлчилгээг хариуцах чиг үүрэг бүхий нэгж байгуулж, бүтэц, орон тоог бий болгох ажлыг эхлүүлнэ.

2.5.1.10. Есөнзүйл сумын Өндөр гэгээний өвгөн суваргыг сэргээгдэх эрчим хүчээр хангана.

**Зорилт 2. Эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой орон нутгийн дэд бүтцийг бий болгож, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.5.2.1. Сумдын төвийн доторх хатуу хучилттай авто замын сүлжээг үе шаттайгаар нэмэгдүүлэн, Улаанбаатар Арвайхээрийн чиглэлийн 60 км авто замын шинэчлэлийг хийнэ.

2.5.2.2. Бат-Өлзий сумын Орхон гол, Цагаан гол, Могойтын гол, Үүртийн тохойн төмөр бетонон гүүрүүд, Могойтын голоос Орхон голын гүүр хүртэл 6,7 километр сайжруулсан авто замыг тус тус ашиглалтад оруулна.

2.5.2.3. Хөдөөгийн багт болон зарим сумдын үүрэн холбооны сүлжээг өргөтгөн, Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсийн холбооны шугам сүлжээний худаг, сувагчлалын ажлыг хийнэ.

2.5.2.4. Орон нутгийн чанартай Бат-Өлзий сумын Улаан голын гүүр, Зүүнбаян-Улаан сумын Нургийн гүүр, Уянга сумын Бөөрөлжүүт, Онгийн гол нийлж буй хэсгийн гүүр, Онгийн голын Олон довд модон гүүр, Нарийнтээл сумын Таацын голын Цагаан толгойн модон гүүр, Хужирт сумын Хадан голын гүүрийг тус тус шинээр барьж, Хархорин сумын Мааньтын хөнөгийн гүүр, Уянга сумын Таац багийн Ар Баруун гол, Өвтийн давааны өвөр хэсгийн модон гүүр, шороон замд засвар хийнэ.

2.5.2.5. Арвайхээр хотод дулааны станцыг барьж, ашиглалтад оруулахтай холбогдуулан дулаан дамжуулах төвүүдийн гадна цахилгаан, холбоо, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

2.5.2.6. Арвайхээр суманд 30 МВт-ын хүчин чадалтай дулааны станцыг ашиглалтад оруулан, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн орон сууц, айл өрхүүдийг дулааны төвлөрсөн сүлжээнд холбоно.

2.5.2.7. Аймаг, сумын төвийн цахилгаан дамжуулах шугамын өргөтгөл шинэчлэлт хийж, аймгийн төв, томоохон суурин газрын шөнийн эрчим хүчний тарифыг тэглэх ажлыг зохион байгуулна.

2.5.2.8. Сумдын төвд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээг бий болгон аж ахуйн нэгж, гэр хорооллын айл өрхүүдийг холбон, орон сууцжуулах нөхцөлийг бүрдүүлж, авто болон явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерээс хамгаалах далан сувгийг төлөвлөлтийн дагуу хийнэ.

2.5.2.9. Сумдын гэр хороолол, багуудад иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулж, Арвайхээр суманд аймгийн Алдартнуудын цэцэрлэгт хүрээлэн бүхий талбайг байгуулна.

**Зорилт 3. Аймаг, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөлтийг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон эдийн засаг,**

**нийгмийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хийж, хаягийн мэдээллийн системийг хөгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.5.3.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.

2.5.3.2. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастр, үнэлгээ, газрын мониторинг, биржийн байнгын ажиллагаатай системийг хөтөлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

2.5.3.3. Аймгийн болон сумдын төв, суурин газруудад хийгдсэн хаягийн зургийг шинэчлэн, хаягжилтын мэдээллийн сан үүсгэж, төрийн байгууллагын мэдээллийн бусад сантай холбоно.

## **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

**Салбарын зорилго:** Нутгийн захиргааны байгууллагын бүх түвшинд засаглалын хариуцлага, шударга ёсыг мөрдүүлж, цахим технологид тулгуурласан, иргэдэд тэгш боломж олгодог, оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлнэ.

### **3.1. Ёс зүй, хариуцлагатай төрийн алба**

**Зорилт 1. Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдааг хангах замаар үр ашигтай бүтэц бүхий мэргэшсэн чадварлаг, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1.1.1. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, давхардал, хийдлийг арилган, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоно.

3.1.1.2. Төрийн албан хаагчийг тогтвортой ажиллах баталгааг хангаж, чадахуйн зарчимд суурилж, төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, тэднийг дотоод, гадаадын сургалт, давтан сургалтад хамруулна.

3.1.1.3. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн санг бүрдүүлнэ.

3.1.1.4. Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагад ил тод, нээлттэй болгоно.

3.1.1.5. Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн эрх зүйн үндэслэлд тогтмол хяналт тавьж, зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

### **3.2. Цахим технологид суурилсан төрийн үйлчилгээ**



**Зорилго 1. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулж, төрийн үйлчилгээг хялбаршуулан, зардал хэмнэх тогтолцоонд шилжүүлэн, төрийн албан хаагчийн ажиллах орчинг сайжруулна.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.2.1.1. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд “Call center” үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх операторын үйлчилгээг сумдад бий болгон, төрийн үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх үйл ажиллагаа явуулна.

3.2.1.2. Төрийн албаны сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулж, үйл ажиллагааг нь ил тод болгоход шаардлагатай техник хэрэгслээр хангаж, төрийн байгууллагуудын интернэтийн хурд, чанарыг сайжруулан, мэдээлэл технологийн ажилтныг чадавхижуулна.

3.2.1.3. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг цахимжуулж, иргэд асуудлын шийдвэрлэлтийн явц, үр дүнг цахимаар хянах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.1.4. Төрийн байгууллага хооронд болон тэдгээрээс иргэний нийгэм, бизнесийн байгууллага, иргэдтэй харилцах мэдээллийн солилцоо, ил тод байдлыг сайжруулж, аймаг, сумдын “Иргэний танхим”-д “Цахим уулзалт”-ыг тогтмол зохион байгуулж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог хялбаршуулна.

3.2.1.5. Хайрхандулаан, Тарагт сумдын Засаг даргын Тамгын газрын барилгыг ашиглалтад оруулж, Есөнзүйл, Богд сумдын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барих, аймгийн Нутгийн удирдлагын ордон, Арвайхээр, Баянгол, Төгрөг, Сант, Өлзийт, Нарийнтээл сумдын Засаг даргын Тамгын газрын барилгыг өргөтгөх, засварлах ажлуудыг гүйцэтгэж, Хужирт суманд төрийн албан хаагчийн байр бий болгоно.

3.2.1.6. Зарим багийн төвүүдийн барилгыг шинээр барих, засварлах, төрийн байгууллагуудын албаны автомашин, компьютер, техник хэрэгслийг шинэчлэх, засварлах болон багийн Засаг дарга нарыг унаагаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хүн амын тоо, нягтаршилд нийцүүлэн зарим сумдад шинээр баг байгуулна.

3.2.1.7. Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчлах зардлыг жил бүр төсөвтөө тусган, мэдээллийн ил тод байдлыг хангахад хяналт тавьж, иргэдэд үнэн бодит мэдээлэл түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч, “Нэг цонхны мэдээлэл” үйл ажиллагааг үр дүнтэй нэвтрүүлнэ.

3.2.1.8. Нутгийн захиргааны байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээнд зориулсан нэгдсэн цахим программыг нэвтрүүлэн, дотоод хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулж, гүйцэтгэлийн хяналт, үр нөлөөг нэмэгдүүлнэ.

3.2.1.9. Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авна.

3.2.1.10. Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах үүрэг чиглэл өгч тухай бүрт хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

3.2.1.11. Зарим төрийн байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо /ISO/-г нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ.

### **3.3.Эрх зүйн боловсролтой иргэн, хүний эрхийг хангасан нийгэм, авлигагүй засаглал**

**Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.3.1.1. Цахим технологид суурилсан арга хэлбэрээр хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.3.1.2. Сум бүрт эрх зүйн танхим, булан байгуулан, сайн дурын эрх зүйн хөтчийг ажиллуулж, иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх, хууль, тогтоомжийн лавлагаа олгох, бусад шаардлагатай хууль зүйн туслалцааны үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.3.1.3. Монгол Улсын хууль, тогтоомж, нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийн аймгийн нэгдсэн санг шинэчлэн, кодификаци хийнэ.

3.3.1.4. Төрийн болон иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа, шийдвэрт хяналт-үнэлгээ хийж, шийдвэр гаргахдаа аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ашиг сонирхлын зөрчилд автахгүй, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглоход анхаарч ажиллана.

3.3.1.5. Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг нэмэгдүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн, олон нийтийн оролцоонд тулгуурласан хяналт, шалгалтын үйл ажиллагаа явуулж, үр дүнг олон нийтэд мэдээлж ажиллана.

3.3.1.6. Аймагт хэрэглэгчийн эрхийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх үүрэг бүхий ажилтныг ажиллуулж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэн, бизнесийн байгууллагуудын шударга бус өрсөлдөөн, үнийн хөөрөгдөл, бүтээгдэхүүний чанар байдлыг хянаж, монополь үүсгэхээс сэргийлж ажиллана.

3.3.1.7. Орон нутаг дахь жендэрийн тэгш байдлыг хангах бодлого зохицуулалтыг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж, байгууллагууд, олон нийтэд жендэрийн боловсрол олгоно.

**Зорилт 2. Олон нийтийг соён гэгээрүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэн, тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.3.2.1. Авлигыг үл тэвчих үзэл хандлагын талаарх нийтлэл, нэвтрүүлгийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлж, түүнийг цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулна.

3.3.2.2. Хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалт, сурталчилгаа зохион байгуулж, авлигыг үл тэвчих үзэл хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр боловсролын байгууллагатай хамтран олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3.2.3. Нутгийн захиргааны бүх байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, үр дүнг тооцон ашиг сонирхлын зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.3.2.4. Төрийн байгууллагуудад дотоод хяналтын нэгж ажиллуулан, төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлнэ.

**Зорилт 3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.3.3.1. “Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.3.3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, аймаг, сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг, гэрлэн дохиог нэмэгдүүлж, теле-камерын хяналтын системийг хөгжүүлнэ.

3.3.3.3. Томоохон голын гүүр, улсын чанартай авто замын дагуу байрлах шатахуун түгээх станц, үйлчилгээний цэг, тээврийн хэрэгслийн зогсоолын цэгүүдэд теле-камер байрлуулах, тээврийн хэрэгслийн улсын дугаар танигч LPR камерыг суурилуулах ажлыг аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор шийдвэрлэнэ.

3.3.3.4. Нийгэмд түгээмэл буй архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бууруулах, таслан зогсоох олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.3.3.5. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд төрийн зарим байгууллагуудыг татан оролцуулж, мал бүрийг бүртгэлжүүлэх, мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулах, малчдын бүлэг, нөхөрлөлийг чадавхжуулах зэрэг цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг эрс бууруулна.

**Зорилт 4. Хууль сахиулах болон зарим хяналтын байгууллагууд, тэдгээрийн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.3.4.1. Аймгийн “Төрийн Архив”-ыг зориулалтын байртай болгож, орон тооны болон гэрээт ажилтанг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд хүргэх үйлчилгээг хялбаршуулна.

3.3.4.2. Аймгийн Прокурорын газрын барилга, Цагдаагийн газрын эрүүлжүүлэх байр, Уянга, Богд, Хужирт сумдын Цагдаагийн тасаг, хэсгийн барилгыг тус тус шинээр барьж ашиглалтад оруулна.

3.3.4.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон Шүүхийн шинжилгээний байгууллагуудад албан хэрэгцээний байр /орон сууц/ шийдвэрлэж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.3.4.4. Стандарт, хэмжил зүй, Мэргэжлийн хяналт, Улсын бүртгэлийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, Улсын бүртгэлийн болон Стандарт хэмжил зүйн хэлтсийн байрны асуудлыг шийдвэрлэнэ.

3.3.4.5. Олон нийтийн цагдаагийн орон тоог нэмэгдүүлэн, ажиллах нөхцөлийг сайжруулж, хувцас, тусгай хэрэгслийн хангалтад дэмжлэг үзүүлж ажиллана.

3.3.4.6. Хархорин суман дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст зарим тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах нөхцөлийг сайжруулна.

#### **3.4.Гадаад харилцаа, хамтын ажиллагаа**

**Зорилт 1. Аймгийн уламжлалт гадаад харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн тэргүүлэх салбарын харилцааг хөгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.4.1.1. Уламжлалт хамтын ажиллагаатай гадаад орнуудын хот, мужуудтай хийх соёл, эдийн засгийн харилцааг өргөжүүлнэ.

3.4.1.2. Гуравдагч хөрш орнуудын хот, мужуудтай шинээр хамтын ажиллагааг тогтоож, олон улсад өрсөлдөхүйц инновац, шинэ технологи, мэдлэг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний бизнес төлөвлөгөө, санал, санаачилгыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулж, хөрөнгө оруулалт татахад дэмжлэг үзүүлнэ.

3.4.1.3. Хамтын ажиллагаатай гадаадын хот, мужуудтай боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, дэд бүтэц, аялал жуулчлалын салбаруудад боловсон хүчнийг сургах, дадлагажуулах, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг явуулна.

3.4.1.4. Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд экспортлох боломжийг судалж хэрэгжүүлнэ.

3.4.1.5. Сумдад гадаадын хот, мужуудтай харилцаа тогтооход нь дэмжлэг үзүүлж, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай идэвхтэй ажиллагааг өрнүүлж эдийн засаг, нийгмийн салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

### **3.5. Батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх**

**Зорилт 1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.5.1.1. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөний дагуу сургалт, бэлтгэлийг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага олгоно.

3.5.1.2. Орон нутгийн хамгаалалтын сургалтын төвийг байгуулж, материаллаг баазыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

3.5.1.3. Аймгийн дайчилгааны төлөвлөгөө болон томилгоот байгууллага, аж ахуйн нэгжийн дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулж, бэлэн байдлыг хангана.

3.5.1.4. Ерөнхий боловсролын бүх сургуулиудад цэрэг-эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг тогтмол хугацаанд хэрэгжүүлж, сумдад цэрэг-эх орны сэдэвт хөшөө, дурсгалын зүйл, бодит түүхийн ой санамжийг сэргээх, илэрхийлэх санал санаачилгуудыг дэмжиж ажиллана.

**Зорилт 2. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.5.2.1. Аймгийн Онцгой байдлын газрын болон Хархорин сум дахь гал түймэр унтраах, аврах ангийг шинээр байгуулж, Хужирт суманд гал түймэр унтраах аврах 3 дугаар зэргийн анги байгуулж, барилгыг ашиглалтад оруулна.

3.5.2.2. Сумдад гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээг аюулын төрөл бүрээр эрх бүхий байгууллагаар хийлгэнэ.

3.5.2.3. Хүн амын төвлөрөл ихтэй суманд эрэн хайх аврах бүлэг байгуулж, алслагдсан сумдад улсын нөөцийн цэг байгуулна.

3.5.2.4. Сумдын гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг чадавхжуулж, зарим тоног төхөөрөмжөөр хангана.

3.5.2.5. Аймгийн Улаан загалмайн хороотой хамтран төрийн хүмүүнлэгийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ.

## **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

**Салбарын зорилго.** Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогыг хэрэгжүүлэн, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

### **4.1.Ногоон хөгжил**

**Зорилт 1. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1.1.1. Усны нөөцийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх зорилгоор булаг шандны эхийг хамгаалж, хөв цөөрөм байгуулна.

4.1.1.2. “Дэлгэрэх гол” төслийг үргэлжлүүлнэ.

4.1.1.3. Арвайхээр, Уянга, Хужирт сумдын төвийн газрын доорх усны эрэл хайгуулын ажлыг хийлгэж, нөөцийн хэмжээг тогтоолгоно.

4.1.1.4. Бат-Өлзий сумын Хуст, Тарагт сумын Хүрэмт, Баруубаян-Улаан сумын Хүрэн хадны рашааны нөөц, физик-химийн найрлагыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгоно.

4.1.1.5. Аймгийн томоохон голуудын урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулан, улсын тусгай хамгаалалтад авах саналыг салбарын яаманд тавьж, Сангийн далайг аймгийн тусгай хамгаалалтад авч, тусгай хамгаалалтад байх газрын тоо, хэмжээг нэмэгдүүлнэ.

4.1.1.6. ”Орхон-Онги” эко төслийг салбарын яамтай хамтран хэрэгжүүлнэ.

**Зорилт 2. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгалийн нөөцийг зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1.2.1. Арвайхээр хотын гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан түлшээр хангаж, агаарын бохирдлыг 50 хувь бууруулна.

4.1.2.2. Хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэн аж ахуй нэгж, байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулж, эх үүсвэр дээр нь ангилж, хөдөө нутаг, гол усны хогийг цэвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

4.1.2.3. Арвайхээр суманд хог хаягдлыг дахин боловсруулах бага оврын үйлдвэр, сумдад цех байгуулж, зарим сумдыг бохир соруулах автомашинаар хангана.

4.1.2.4. Гэр хороолол, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгжүүдэд дэвшилтэт технологи бүхий “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.

4.1.2.5. Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нөөцийн судалгааг өргөжүүлж, хамгаалалтын менежментийг сайжруулна.

4.1.2.6. Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, орхигдсон газруудад нөхөн сэргээлт хийж, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдэд хуулийн хариуцлага тооцон ажиллана.

4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар бүтээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.1.2.8. Байгаль орчны салбарын хүний нөөцийг чадавхжуулах урт богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамруулан, ажиллах нөхцөл, материаллаг баазаар хангана.

4.1.2.9. Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн үйл ажиллагааг тогтмолжуулан, шаардлагатай цэгт газрын генератор байршуулж, цөлжилт, ган хуурайшилтын эрсдэлийг бууруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

**Зорилт 3. Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хомсдол, доройтлыг зогсоох, нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой, тогтвортой ашиглахад чиглэсэн менежментийг бүрдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1.3.1. Мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагуудыг бодлогоор дэмжиж, ойжуулалт, төв суурингийн ногоон байгууламжид шаардлагатай тарьц, суулгацаар аймгийн хэрэгцээг бүрэн ханган, ойжуулах ажлыг төсөл хөтөлбөрт хамруулах санаачлага гарган ажиллана.

4.1.3.2. Ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, унанги мод цэвэрлэх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн одоогийн байгаа түвшинг тогтвортой хадгалах нөхцөл бүрдүүлнэ.

4.1.3.3. Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, Арвайхээр хотын ногоон байгууламжийн хэмжээг 50 хувь нэмэгдүүлнэ.

## **4.2. Аялал жуулчлал**

**Зорилт 1. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.2.1.1. Аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн онцлогт тулгуурлан аялал жуулчлалын цогц арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аймгийн аялал жуулчлалын цахим мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.

4.2.1.2. Төвхөн хийдийн угтах орчныг сайжруулах, байгальд ээлтэй аялал жуулчлалыг дэмжих бодлого хэрэгжүүлж, Монгол Улсын төв цэгийн “Гал голомт цогцолбор” төсөл хэрэгжүүлж эхэлнэ.

4.2.1.3. Хархорин, Эрдэнэзуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулна.

4.2.1.4. “Хархорин XIII зуун” төсөл хэрэгжүүлж, эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурийг ил музей болгоно.

4.2.1.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Өндөр гэгээн Г.Занбазарын үйл хэргийг мөнхжүүлэх цогцолбор төвийг байгуулж эхэлнэ.

4.2.1.6. Зарим иргэдийг хөтөч, угтан үйлчлэгчийн зэрэг сургалтад хамруулж, нутгийн онцлогтой аялал жуулчлалыг хөгжүүлэн, бүтээгдэхүүн, үйлчилгээний, чанар, стандартыг сайжруулан жуулчдын тоог суурь түвшингээс 50 хувиар нэмэгдүүлнэ.

4.2.1.7. Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж, аялал жуулчлалын эргэлтэд оруулан, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4.2.1.8. Аялал жуулчлалын гол чиглэл дагуу дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборыг байгуулна.

4.2.1.9. Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.2.1.10. Аялал жуулчлалыг дараах маршрутаар хөгжүүлнэ. Үүнд:

- **Орхоны хөндийн аялал жуулчлалын маршрут:** Элсэн тасархай, Их, бага Монгол уул - Ширээт цагаан нуур - Монгол орны төв цэг, Хархорин-Эрдэнэзуу - Шанхын хийд – Хархорум музей - Хужирт сумын халуун рашаан, Үүртийн тохой - Төвхөн хийд, Улаан цутгалан - Бат-Өлзий сум
- **Тусгай сонирхлын аяллын маршрут:** Найман нуур, Орхоны хүрхрээгийн мөсний авиралт, Хужирт, Бат-Өлзий, Тарагт, Нарийнтээл, Зүүнбаян-Улаан сумдын халуун рашаан,
- **Говийн болон баруун бүсийн сумдын аяллын маршрут:** Арвайхээр, Мазар хотын туурь - Өөш шахлага - Арц богдын нуруу - Зүүн богд уул – Хүрэн хадны рашаан - Элсний эмчилгээ -Таацын цагаан нуур - Өшгөгийн их залаа - Өнц шилүүстэй - Шаргын тасархай, Шаамын рашаан - Хубилай хааны цэргийн хотын туурь.
- **Өндөр гэгээн Занабазарын түүхэн замналаар аялах маршрут:** Элсэн тасархай – Их, бага Монгол уул - Ширээт цагаан нуур - Монгол орны төв цэг, Өвгөн суварга - Сэрүүн булаг-Сангийн далай – Арвайхээр сумын Өндөр гэгээн Г.Занабазарын цэцэрлэгт хүрээлэн.
- **Зүүнбаян-Улаан сумын аялал жуулчлалын маршрут:** Цагаан бургас болон Баянзүрх хайрханы энергийн төв.



4.2.1.11. Сум бүрт байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын сүлжээ бий болгож, түүнд түшиглэсэн соёлын үйлдвэрлэл, брэнд бүтээгдэхүүн бий болгоно.

4.2.1.12. Аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж, ажиллана.

## **ТАВ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО**

**Зорилт 1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.1.1. Халдварт цар тахлын үед нийгмийн хамгааллын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

5.1.2. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

5.1.3. Цар тахлын үед түлээ, нүүрс, хүнсний хомсдолд орж болзошгүй иргэдэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч, дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

5.1.4. Түлээ, нүүрс, хүнс, шатахуун зэрэг өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл, савлалт, хүргэлт, тараалт, борлуулалтыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, үнийн өсөлт үүсэхээс сэргийлж ажиллана.

5.1.5. Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа, сургалтийн үйл ажиллагаа зохион байгуулна.

5.1.6. Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад чиглэсэн дэмжлэг, тусалцааг нэмэгдүүлэх чиглэлээр түнш улс орны муж, хотууд болон олон улсын байгууллага, иргэдтэй идэвхтэй хамтран ажиллана.

5.1.7. Отор нүүдэл хийж байгаа малчдад эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг хүргэх, мал сүргээ онд оруулах талаар отор хүлээн авагч аймаг, сумдтай хамтран ажиллах замаар орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хадгална.

5.1.8. Иргэн, аж ахуйн нэгжүүдийн зээл, татвар, нийгмийн даатгал, түрээсийн нөхцөлийг хөнгөрүүлэх Засгийн газрын бодлогыг орон нутагт хэрэгжүүлж, ажлын байраа хадгалахад нь дэмжлэг үзүүлнэ.

**5.2. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.2.1. Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор аймаг, сумын Засаг даргын нөөц сангийн гамшгаас хамгаалах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

5.2.2. Төр болон хувийн хэвшлийн байгууллагууд цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ.

5.2.3. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд хамруулна.

5.2.4. Халдварт өвчний голомтод ажилласан албан хаагчдад урамшуулал, дэмжлэг олгоно.

5.2.5. Коронавируст халдварын батлагдсан тохиолдолд хэрэглэгдэх вирусийн эсрэг эм, сонгомол антибиотик, үрэвслийн эсрэг эм, тариа, оношлуур, хамгаалах хэрэгслэлийн нөөцийг бүрдүүлнэ.

5.2.6. Цар тахлын үед Арвайхээр сумын баруун, зүүн нэвтрэх, хяналтын цэгүүдэд ажиллах албан хаагчдыг интернетийн сүлжээнд холбох замаар бүртгэл, хяналтыг зохих шаардлагад хүргэнэ.

**5.3.Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.3.1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газарт халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн шуурхай удирдлагын нэгжийг байгуулна.

5.3.2.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг бий болгож, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.

5.3.3.1000 ор бүхий хээрийн эмнэлгийг төрөл бүрийн хэлбэрээр бий болгож, бэлэн байдлыг хангана.

5.3.4.Сум, өрхийн лабораторийг өргөжүүлж, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийг РТ-ПСР төхөөрөмжөөр хангана.

5.3.5. Тархвар судлал, халдварт, зоонозын халдварт өвчний чиглэлээр эмч мэргэжилтнийг бэлтгэх, сургаж, чадавхжуулах, орон тоог нэмэгдүүлнэ.

5.3.6. Сумдын Эрүүл мэндийн төвийн халдвартын тасгийг өргөжүүлж, байрны асуудлыг шийдвэрлэнэ.

5.3.7. Цар тахлын үед ажиллах тусгаарлах болон тусгаарлан ажиглах байрыг томилгоожуулж, бэлэн байдлыг хангана.

5.3.8. Сумдын эмнэлэг, Эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох асуудлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.3.9. Халдварт хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах орчин үеийн дэвшилтэт технологит суурилсан байгууламжийг бэлэн болгоно.

5.3.10. Цар тахлын үед ажиллах мэргэжлийн байгууллага болон дэмжлэг үзүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллах төлөвлөгөөг боловсруулж, зарим дадлага, сургуулилтыг зохион байгуулна.

5.3.11. Эрүүл мэндийн байгууллагуудад цаасгүй буюу цахим технологийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

5.3.12. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулна.

#### **5.4. Цар тахлын үед боловсролын үйлчилгээг тасралтгүй тэгш, хүртээмжтэй явуулах нөхцөлийг бүрдүүлж, ажиллана.**

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.4.1. Хорио цээрийн дэглэмийн үед хэмнэгдсэн зардлыг тооцож, нэн шаардлагатай арга хэмжээнд аймгийн Онцгой комиссын шийдвэрийг үндэслэж, зарцуулна.

5.4.2. Сурагчдад цахимаар явуулах хичээлийн цагийг зохистой хэмжээнд хүргэхийн зэрэгцээ, сургалтын хөтөлбөрийн хоцрогдол гаргахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.4.3. Цар тахлын үед сургалтын байгууллагын орчинд халдваргүйтгэл хийж багш ажилчдыг халдвар хамгааллын хувцас хэрэгслээр хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.4.4. Сургууль, цэцэрлэг бүр цахим, теле хичээл бэлтгэн, технологийн сан бүрдүүлж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл сургалтыг тасралтгүй үргэлжлүүлж, танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин, тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулна.

-оОо-

Өвөрхангай аймгийн Засаг даргын  
2020-2024 оны үйл ажиллагааны  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д”, 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нэгдүгээр, түүний хэрэгжилтийг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021 оны нэгдүгээр улиралд багтаан баталж, аймгийн хөгжлийн жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /А.Ишдорж/-д даалгасугай.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ